

ДеФакто **ТОЙМ**

СОНГУУЛЬД БЭЛДСЭН
ТӨСӨВ ҮҮ?

ВАЛЮТЫН ХАНШИЙГ ХУУЛИАР
ЗОХИЦУУЛДАГ ҮҮ?

ЗАСГИЙН ГАЗАРТ ГОЛОГДСОН
ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Хөрөнгийн урсгалыг
БООХ САНАА

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2018.10.18, №68

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН, УЛС ТӨРИЙН
НАМААС ХАРААТ БУС ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Хөрөнгийн үрсгэлийг БООХ САНАА

Төгрөгийн ханш суларч, доллар чангарч байна. Сүүлийн гучин жил үргэлжилж буй хандлага. Эдийн засагт эргэлдэж буй төгрөгийн өсөлтөөс долларынх нь хоцроод буй хэрэг.

Монголчууд тоног төхөөрөмж, унаа тэрэг, ер нь бүх хэрэглээний бараагаа гадаадаас доллараар авдаг. Энэ жил гэхэд л ноднингтоос 40 хувиар илүү бараа импортлоод байна. Гадагшаа бид нүүрс, зэс, төмрийн хүдэр гэх мэт хэдхэн эрдэс экспортлож доллар олдог. Эдүгээ харин экспорт, импортын зөрөөгүй буюу гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа.

Харин төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа. Энэ тэнцлийн тухай улс төрчид ярихаас цэрвэж, тойроод байдаг учир нь үүнийг тэд бий болгодог. Монгол улсын гадагшаа

төлж буй өр төлбөрийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хоцроод байхаар энэ алдагдал бий болдог. Төлбөрийн тэнцлийн алдагдал гарахаар төгрөгийн ханш унадаг.

Монгол улсын Засгийн газрын гадаад өр нь эдийн засгийнхаа (ДНБ) 70 хувьтай тэнцээд байна. Энэ том зээлээ, хүүтэй нь төлөх гэж гадагшаа доллар гаргаад, гаднаас хөрөнгө оруулалт нэмж татахын оронд, орж ирснийг нь үргээж, айлгах боллоо.

Өр нэмэгдээд буй нь төсвийн алдагдлаас үүдэлтэй. Гэтэл төр засаг төсвөө жил бүр алдагдалтай төлөвлөж, төлөвлөснөөсөө том алдагдал гаргаж, "тодотгох нэрээр" нэмж зээл авдаг болсон. Одоо ч гэсэн тийм л төсөв УИХ батлах гэж байна.

ЗАСГИЙН ГАЗРААС ХАРААТ МОНГОЛБАНК

Мөнгөний бодлогоо "улс төрийн болон засгийн газрын нөлөөлөлгүй" явуулахыг хараат бус байх гэдэг (Карл Э.Велш, 2006). Ж.Дэлгэрсайхан, Б.Алтанзул нарын судлаачид 2015 онд "Cukierman индексийг" ашиглан төв банкны хуулийн зохицуулалт, хэрэгжилтийг дүгнэж, мэргэжилтнүүдийн дунд санал асуулга явуулжээ. Үр дүн нь 0.446 буюу Монголбанк Засгийн газраас хараат гэж гарав.

Мөнгөний бодлого нь Засгийн газраас хараат оронд гадаад валютын нөөц нь бага, мөнгөний ханш нь унах хандлагатай байдгийг Грек, Аргентин, Зимбабве, Венесуэл зэрэг олон орны жишээн дээр харж болно.

Хараат учраас Монголбанкны өөрийн хөрөнгө

үргэлж буурч ирсэн бөгөөд шалтгаан нь Засгийн газартай хамтраад төсвийн шинж чанартай үйл ажиллагаа явуулсантай холбоотой гэж дээрх судлаачид дүгнэжээ. "Үнэ тогтворжуулах хөтөлбөр", тодорхой салбарт чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр арилжааны банкуудад олгосон, зах зээлийн бус зарчмаар валютын ханшийн зөрөөний хөнгөлөлттэй санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл, хуулийн гадуур зарим хэлцэл хийснийг судлаачид онцолжээ.

Өнөөдөр Монголбанк мөн л улс төрийн дарамтанд орж Засгийн газрын дотоод өрийг шилжүүлэн авах болсноор ТБҮЦ-ны өрийн үлдэгдэл хоёр жилийн дотор 10 дахин өсч 4.3 их наяд болоод байна. Иргэдээс алт худалдан авах нөхцлөө



- ▶ сулруулснаар жилд 20 тонн алт авч эхэлсэн нь гадаад валютын нөөцийг нь нэмэгдүүлэв. Тэгтэл төр засгаас МБ-ыг ханшийн интервенц хийхийг шахах боллоо.

Төгрөг суларч буйн суурь шалтгаан нь төлбөрийн тэнцлийн алдагдал байхад МБ

бүх нөөцөө зараад ч ханшийг барьж чадахгүй юм. Харин түүний оронд төр засаг авсан зээлээ өгөөжтэй ашиглаж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмж татах шаардлагатай.

МОНГОЛ УЛС БАНКНЫ СИСТЕМЭЭ ӨӨРЧЛӨХ ҮҮ?

Энэ өдрүүдэд валют зохицуулах нэртэй хоёр ч хуулийн төслийг УИХ хэлэлцэж эхэллээ. Нэгийг нь Ерөнхийлөгч, нөгөөг нь УИХ-ын дөрвөн гишүүн өргөн барьжээ. Ерөнхийлөгчийн санаачилсан төсөлд Валютын зохицуулалтын тухай хуулийн 14.10 дахь хэсэгт “Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигладаг...хуулийн этгээдийн төлбөр тооцооны дансыг Монголбанк өөр дээрээ байршуулж болно” гэж оруулахыг санал болгожээ.

Харин УИХ-ын гишүүн М.Оюунчимэг нарын төсөлд: “Монголбанк Монгол улсын эдийн засаг, төсвийн орлогын бүрдэлтэд чухал ач холбогдолтой, стратегийн хөрөнгө оруулагч, эдийн засгийн

харьяат бус этгээдэд харилцан тохиролцсоны үндсэн дээр валютын данс нээж, төлбөр тооцоо гүйцэтгэж болно” гэжээ.

Төв банкны хуулиар Монголбанк өөрөө иргэдээс алт худалдаж авахаас өөр арилжаа явуулахгүй, банкны бүх арилжааг зөвхөн арилжааны банкууд явуулах ёстой. Хэрэв дээрх хоёр саналыг нэгтгээд батлавал Төв банкны хуулинд бас өөрчлөлт оруулж Төв банк томоохон хөрөнгө оруулагчийн валютын дансыг өөр дээрээ нээх эрхтэй болох юм. Гагцхүү энэ үйлдэл нь Монгол улсын хоёр шатлалтай банкны системийг өөрчлөх эхлэл болох эсэхийг хууль тогтоогчид тунгаах ёстой.

КАПИТАЛЫН УРСГАЛЫГ ХЯНАХ УУ?

УИХ дээр хэлэлцэж эхэлсэн дээрх шинэчилсэн хуулийн төслийн 16.1.3-д “Монгол улсын гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор иргэд, хуулийн этгээд, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно; 16.1.6. Монгол улсын хилээр орох, гарах бэлэн валютад хязгаарлалт тогтоох; 17.1.3. төгрөгийн ханшид үзүүлэх нөлөөг харгалзан гүйлгээнд хязгаар тогтоож болно зэргээр заасан нь Монгол улс валютын урсгалыг төрөөс нь боох (capital control) гэж буйг илтгэж байна.

Энэ төрлийн заалтууд нь эдийн засагт ирээдүйд орж ирэх валютын урсгал, гадаадын хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчдийн сонирхол, нийт мөнгөний нийлүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлдгийг хөгжиж буй олон орнуудын алдаанаас харж болно. Ийм бодлого явуулсан орнууд үргэлж хохирч, нийгэм, эдийн засгийн хөгжил нь зогсож, олон жил алдахаас гадна засч залруулахад нэгэн үе шаардана. Хуулинд ийм зохицуулалт оруулах нь хэрэгжүүлсэн эсэхээс үл хамаарч гадаадын хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд шууд сөргөөр нөлөөлнө.

Ийм заалттай хууль гарвал хөрөнгийн урсгал, валютын гүйлгээ, арилжаанд төрөөс хязгаарлалт хийдэг орнуудын жагсаалтад Монгол улс орж, улмаар манайд хөрөнгө оруулах, зээл өгөх сонирхол алга болно. Өрөндөө бүрэн баригдаж живэх үеэр туслах улс орон гарч болох ч эдийн засгийн аюулгүй байдал алдагдана.

Монголын төр засаг ийм хууль гаргаж төгрөгийн ханшийг тогтворжуулахыг оролдож байгаа нь үнэхээр өндөр эрсдэл дагуулах юм.

Ханшийг амжилттай барьж ирсэн ганцхан арга бол Мөнгөний Зөвлөл (currency board) байгуулах явдал. Тэгэхдээ тухайн улс мөнгөний нийлүүлэлттэйгээ тэнцэх гадаад валютын нөөцтэй байх учиртай. Манайх 2500 төгрөг дээр долларыг “уяна” гэвэл 20 их наяд төгрөгтэй тэнцэх буюу наад зах нь 8 тэрбум долларын нөөцтэй байх ёстой.

Одоохондоо ийм нөөц байхгүй учир төсвөө алдагдалгүй батлаж, өрөө цагт нь төлж, улс орон даяар бүсээ чангалж амьдрах л үлджээ.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2018.10.14-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

СОНГУУЛЬД БЭЛДСЭН ТӨСӨВ ҮҮ?

2 долоо хоногийн өмнө Сангийн сайд Монгол улсын 2019 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барьсан. Чүнд 2019 оны төсвийн хүрээний мэдэгдлээс орлогыг 800 орчим тэрбум төгрөгөөр, зардлыг 600 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Эдгээр өдрүүдэд 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа ба Ерөнхийлөгч Х.Баттулга "Энэ жилийн төсөв нь 2020 оны сонгуульд нөлөөлөх талаар илүү бодсон, ашиг сонирхлын зөрчилтэй" гэж мэдэгдсэн.

Төсөв өнгөрсөн жилүүдээс орлогоороо ч тэр зардлаараа ч тэр томорч байгаа. 2018 оны төсөв 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай байсан бол 2019 оны төсөв 1.9 их наядын алдагдалтай буюу энэ нь ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэж байгаа. Төсөв гэдэг нь ЗГ орлого зарлагаа төсөөлөн тооцсон тухайн улсын, тухайн санхүүгийн жилийн тайлан юм л даа. Улс орны эдийн засагт төсвийн зарлага эдийн засгийнхаа хэдэн хувийг эзлэж байна гэдэг нь чухал үзүүлэлт болж байдаг. Манайд бол төсвийн зарлага ДНБ-ийнхээ 33 хувь байгаа. 2019 онд зарлагыг 11.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 32.8%. Өндөр хөгжсөн орнуудад энэ нь 20 хүртэлх хувь л байдаг. Улс орон хөгжихийн хэрээр энэ тоо багасах ёстой.

Европын холбооны 28 улсад төсвийн алдагдлын дээд хязгаарыг 2 хувь гэж тооцсон байдаг ч өнөөдөр 1 хувь ч хүрэхгүй байгаа. Мөн тухайн улсын ЗГ-ын өр эдийн засгийнхаа хэдэн хувь байна гэдэг нь чухал. Манайд 70 орчим хувь байдаг бол Европын орнуудад 60 орчим л байна. Японы ЗГ эдийн засгаасаа 2,3 дахин илүү өртэй. Гэвч ялгаа нь тэдний өр дотоодынх нь валютаар буюу Иенээр. Харин манай энэ үзүүлэлт доллараар байдаг тул ханшийн эрсдэл их болоод төгрөг сулрах хэмжээгээр гадаад өрийн хэмжээ нэмэгддэг. Өнөөдөр манай эдийн засаг 35.4 их наяд төгрөг байгаа ба

доллараар бол 14 тэрбум долларын эдийн засаг байна. Гэтэл бид 2011 онд 11 тэрбум долларын эдийн засаг байлаа шүү дээ. Ер нь бол ийм их хэмжээний гадаад өртэй эдийн засаг төсөв нь ямар ч алдагдалгүй тооцоотой байх ёстой.

Төсвийн төсөөллийг их өөдрөгөөр хардаг л даа. Ялангуяа сонгуулийн өмнөх жил. Нүүрсний үнэ өснө гэж байгаа ч үнэн хэрэгтээ одоо нүүрсний үнэ буурах хандлагатай байна. Муу төсөв хийгээд сүүлд өнгөрсөн хойно нь тодотгодог аргатай болсон шүү дээ. Хувийн хэвшлийн хэмжээ аль зэрэг том бэ гэдгийг бид төсвөөс төдийлөн хардаггүй.

Мөн Засгийн газар үнэ тогтоосон хэвээрээ байна. Цахилгаан, нийтийн тээвэр, боловсрол, эрүүл мэнд зэрэг зах зээлийн тогтоож болох үнийг төр тогтоочихоор үр дүнд нь зөвхөн улс төрчдөд л ашигтай байна. Ард иргэдэд чөлөөт тогтоосон үнэ л хамгийн зөв гэдгийг хэн ч хэлж өгөхгүй байна шүү дээ.

Татварын багц хууль батлагдаагүй байхад батлагдсан гэж үзээд хамаг төлөвлөгөөгөө өөдрөг хийчихэж байгаа байхгүй юу. Улс төр, эдийн засгийн гол асуудал нь тогтолцоо муу байгаадаа биш, хууль журмаа сахиулж чадахгүй байгаад л хамаг асуудал байгаа. Хууль журмаа сахиулж чадахгүй тогтолцоо бий болчихсон байна. Эсвэл 2 танхимтай их хуралтай болоод Ерөнхийлөгчөө Ерөнхий сайд болгох хэрэгтэй.

ВАЛЮТЫН ХАНШИЙГ ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ ҮҮ?

УИХ-ын гишүүн М.Оюунчимэг нарын дөрвөн гишүүн Валютын зохицуулалтын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, цүнхийг нь УИХ хэлэлцэж буйтай холбогдуулан Ерөнхийлөгчийн Талмгын газрын дарга З.Энхболд Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилсан Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дахин өргөн барьсан. Энэ оны 6-р сард энэ хуулийг УИХ-ын чуулганаар хэлэлцэж, хууль санаачлагчид нь буцааж байсан.

Одоо валютыг зохицуулах 2 төрлийн хуулийн төсөл гараад ирлээ. Валютын ханшийг ямар ч хуулиар хаана ч зохицуулж байгаагүй юм аа. Харин зохицуулах гэж оролдоод дампуурсан орнууд бол байгаа. Зимбабве, Венесуэль, Турк зэрэг улс үүнд орно. Тэвэрч болохгүй юмыг тэврэх гэж оролдсон улс төрчдийн ийм ойрын хараатай бодлогоос болоод эхний 1,2 жилдээ зохицуулж байгаа юм шиг харагдаад, дараа нь уруу руу улам хурдтай өнхрөх аюултай.

М.Оюунчимэг гишүүн хэлэхдээ “Инфляцийн түвшин нам байхад, төгрөгийн ам.доллартай харьцах ханш огцом суларч байгаа нь ард иргэдийн төгрөгт итгэх итгэлийг бууруулж, албан бус долларжилтийг бий болгон, ам.долларыг шүтэх нийгмийн сэтгэлзүй, хэрэглээ байсаар байна” гэж хэлсэн. Яг ийм үг Эрдоган хэлж байсан байхгүй юу. Асуудал ам.доллар шүтэхдээ бус асуудал хүмүүс сонголттой байх ёстой. Хүмүүс өөрийн бий болгосон хөрөнгөө ус болгохыг хэзээ ч хүсэхгүй учраас ам.доллар байна уу, чөтгөрийн доллар байна уу хамаагүй орно. Хүн, мөнгө, ус гурав эрх чөлөө рүү урсдаг.

Долларын ханшийг барихын тулд чөлөөтэй орхих ёстой. Манайх шиг гадаад өр ихтэй орон долларын ханшийг барих хэцүү байдаг учраас гадаад өрөө л багасгах ёстой. Экспортыг зөвхөн уул уурхайгаар төсөөлөхгүй өөр салбаруудыг хөгжүүлэх ёстой. Үүнийг хувийн салбар л хийнэ. Тиймээс хувийн салбарт өрсөлдөх боломжийг нь олгоод өг. Төр засгийн ажил нь ханш барих биш. Энэ бол зах зээлийнх нь ажил. Төр засаг, Монголбанк хоёр ханшийг барьсан дүр үзүүлж болно л доо. Гэхдээ чадахгүй юмыг барьж авах гэсээр сүүлд нь Монголбанк нөөц ч үгүй болмогц ханш зогсолтгүй унана.

Ханшийг тогтворжуулах ганц л арга нь хувийн секторыг хүчтэй болгож, төр засгийн газрын өр тавихыг болиулж, төсвийг алдагдалгүй байлгах арга хэмжээг авах ёстой. Төсөв л алдагдалтай байгаа бол ЗГ төгрөгийн ханшийг санаатайгаар мэдэгдэлгүйгээр унагаж байгаа хэрэг.

Инфляци бол төрийн бодлогын аль зэрэг ухаалаг байгааг харуулдаг үзүүлэлт. 2-3 хувийн инфляци бол хүлээн зөвшөөрөгддөг харин үүнээс дээш бол төрийн бодлогын мууг л харуулдаг.

ЗАСГИЙН ГАЗАРТ ГОЛОГДСОН ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Сангийн сайд 2019 онд Ипотекийн зээл олголт Монголбанк дээр хэвээрээ үлдэнэ гэж хэлсэн. Уг нь бол ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Засгийн газартай тохирсны дагуу Ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс Засгийн газарт шилжүүлнэ гэж байсан.

Монголбанк 2018 оны есдүгээр сард ипотекийн зээлд зориулж 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгож, 239 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдсан. Энэ оны эхний 9 сарын байдлаар Монголбанкны эх үүсвэрээс 143.7 тэрбум төгрөг, Засгийн газрын эх үүсвэрээс 59.6 тэрбум төгрөг, нийт 203.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 2,963 иргэнд олгосон байна. 2019 оны төсөвт ипотекийн зээлд 115 тэрбум төгрөг тавьсан байна.


Энэ ипотекийн зээл зүй нь бол Монголбанкинд хамаагүй байхгүй юу. Засгийн газар өөрөө эхлэж хийх ёстой байсан юмыг яагаад ч юм Монголбанк хийгээд өдийд 4.2 их наяд төгрөг гаргачихсан байна. Гэхдээ бид 2 дахин өндөр үнээр орон гэр олж авч байна шүү дээ. Хэрэв ипотекийн төслийг хийгээгүй байсан бол барилгын хэдэн компани, тэдэнд зээл өгсөн хэдэн банкны зарим нь дампуурна, зарим нь

хөрөнгөө өөрчилнө, үр дүнд нь барилгын үнэ буурах байсан шүү дээ. Өнөөдрийн үнээс 2 дахин бага үнээр зарагдах ёстой байсныг ийм байдалд хүргэсэн. 2019 онд ипотекийн зээлийг угаас алдагдалтай байгаа ЗГ өөр дээрээ бичиж чадахгүй, бичлээ гэхэд Монголбанкинд маш том “нүх” үлдэнэ. Тэр “нүхээ” алдагдал л гэж бичнэ шүү дээ.

Гэр хорооллоос байранд орж байгаа бол, гэр хорооллын бүс дотор барьж байгаа байшинд бол, ногоон зээл гэсэн 3 нөхцөлд л ипотекийн зээл өгнө гэсэн байна лээ. Энэ бол төр засагт ер нь байхгүй шахуу үзэгдэл болчихоод байна.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН

GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com